Ази-Номхон далайн бүсийн орнуудын Хэрэглэлийн нислэгийн журам боловсруулах төслийн төвийн удирдах зөвлөлийн анхдугаар хуралдаанд оролцсон ИНЕГ-ын Дэд дарга Б.Алтанцомын тайлан

БНХАУ-ын Бээжин хотноо 2010 оны 5 дугаар сарын 11-нээс 13-ны өдрүүдэд зохиогдсон Иргэний нисэхийн олон улсын байгууллага(ИКАО)-ийн Ази Номхон далайн бүсийн орнуудын Хэрэглэлийн нислэгийн журам(ХНЖ) боловсруулах төслийн төвийн анхдугаар хуралд ИНЕГ-ын Аэронавигацийн үйлчилгээ хариуцсан дэд дарга Б.Алтанцом, Аэронавигацийн мэргэжлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Баярсайхан нар оролцлоо.

Тус хуралд ИКАО-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга ноён Раймонд Бенжамин, ИКАО-ийн Ази Номхон далайн бүсийн төвийн Нислэгийн аюулгүй байдлын менежер ноён Фарийд Али Шах болон Австрали, Бруней Даруссалам, БНХАУ, БНАСАУ, Франц, Хонг Конг, Макао, БНСУ, Сингапур, Тайланд зэрэг улс орнуудын төлөөлөгчид, АНУ-ын Иргэний нисэхийн удирдах газар /FAA/, Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбоо /IATA/, Европын холбооны Нисэхийн аюулгүй байдлын байгууллага /EASA/, Дэлхийн газар зүйн мэдээлэлийн системийн тэргүүлэгч байгууллага /ESRI/, Аэробус, Боинг, Хонейвелл /Honeywell/ зэрэг компаниудын төлөөлөгчид нар оролцсон болно.

ИКАО-ын Ерөнхий Чуулганы А36-23 дугаар шийдвэрээр Бүх улс орнуудыг нислэг хөдөлгөөний удирдлагатай агаарын замууд болон хэрэглэлийн нислэгээр оролт үйлдэх журмуудыг ИКАО-ын Үзүүлэлтэд тулгуурласан навигаци(PBN)-ын Гарын авлага (Doc 9613)-ын дагуу шинэчлэн тогтоох шаардлагын дагуу ИНЕГ нь PBN-ыг хэрэгжүүлэх богино (2010-2013), дунд (2013-2016) болон урт (2016 оноос хойш) хугацааны гэсэн гурван үе шаттайгаар хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргасан. PBN-ны төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхийн тулд улс орнуудад шинэчлэгдэх хэрэглэлийн нислэгийн журмыг шинэчлэн боловсруулах сургалт зохион байгуулах, дадлага олгох зорилгоор ИКАО-ын Ази-Номхон далайн бүсийн төв 2009 оны 11 дүгээр сард БНХАУ-ын Бээжин хотод ХНЖ боловсруулах төслийн төвийг шинээр зохион байгуулсан билээ. Монгол Улсын Иргэний нисэхийн ерөнхий газар уг төсөлд идэвхитэй оролцогч гишүүнээр элсэн орлоо.

ИКАО-ийн Ази Номхон далайн бүсийн орнуудын ХНЖ боловсруулах төслийн төвийн анхдугаар хуралдаанаар дараахи асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэв. Үүнд:

- Ази-Номхон далайн бүсийн ХНЖ боловсруулах төслийн төвийг албан ёсоор нээх ёслолын арга хэмжээ болж тус төв үйл ажиллагаагаа эхэлснийг зарлав.
- Ази-Номхон далайн бүсийн ХНЖ боловсруулах төслийн төвийн удирдах зөвлөлийг идэвхтэй оролцогч гишүүн 10 улс болох БНХАУ, БНАСАУ, Хонг Конг, Макао, Монгол, БНСУ, Сингапур, Тайланд, Франц Полинейза, Пакистан улсуудын төлөөлөлийг оролцуулан байгуулав.

- Ази-Номхон далайн бүсийн ХНЖ боловсруулах төслийн төвийн захирлаар тус төвийн менежер ноён Даве Ваннессийг сонгов.

- Ази-Номхон далайн бүсийн ХНЖ боловсруулах төслийн төвийн үйл ажиллагааны 2010 оны төсөв 155800 ам. Доллар, 2011 болон 2012 онуудад тус бүр 179400 ам. Доллар байхаар ноён Даве Ваннесс төлөөлөгчидөд танилцуулж хэлэлцүүлэхэд Австрали улсаас бусад бүх орны төлөөлөгчид зөвшөөрсөн санал өгч батлуулав. 2010 онд идэвхитэй оролцогч орны татвар 16000 ам. Доллар байх бөгөөд уг татварыг 2010 ондоо багтааж төлөхийг улс орнуудад сануулав.
- Тус хуралдаанд ХНЖ боловсруулах төсөлд идэвхитэй оролцогч гишүүнээр элсэхийн ашиг тусын талаар Францын Иргэний нисэхийн удирдах газраас ноён Фабиен Динклаукс, ХНЖ боловсруулах тооцоог хийгч GeoTitan программ хангамжийн талаар Францын Иргэний нисэхийн их сургуулийн танхимын эрхлэгч хатагтай Коринне Боускует болон ноён Марк Чиеса нар, нислэгийн газрын зургийг дижитал хэлбэрт оруулагч программ хамжийн талаар Дэлхийн газар зүйн мэдээлэлийн системийн тэргүүлэгч байгууллага /ESRI/-ын БНХАУ-ын Бээжинд дэх төлөөлөгчийн газрын төлөөлөгч ноён Лин Шуеэлин, Дэлхий нийтийн хэмжээнд PBN-ыг хэрэгжүүлж буй үйл ажиллагааны явцын талаар ИКАО-ийн Ази Номхон далайн бүсийн төвийн нислэгийн аюулгүй байдлын менежер ноён Фарийд Али Шах, Тайланд улсад PBN-ыг хэрэгжүүлж буй үйл ажиллагааны явцын талаар Аэротай компаний мэргэжилтэн ноён Ноппадол Прингванич, PBN-ыг хэрэгжүүлэхэд Агаарын орон зайн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх талаар Боинг компанийн ахлах менежер ноён Жефф Робертс, Агаарын хөлгийн загвараас хамаарч PBN-ны ямар төрлүүдийг хэрэглэж болох талаар Аэробус компаний онгоцны дарга ноён Жеан Девиллэ, Австрали улсад PBN-ыг хэрэгжүүлж буй үйл ажиллагааны явцын талаар ноён Петер Кромарти, Франц Полинейза болон Шинэ Каледониа улсуудад PBN-ыг хэрэгжүүлж буй үйл ажиллагааны явцын талаар ноён Фабиен Динклаукс, БНСолонгос улсад PBN-ыг хэрэгжүүлж буй үйл ажиллагааны явцын талаар ноён Парк Жоонсоо нар танилцуулгууд хийсэн.
- Төвөөс 2010 онд зохион байгуулах сургалт, үйлдвэрлэлийн дадлага, техник туслалцааны айлчлал хийх төлөвлөгөөг хэлэлцэн батлав. Үүнд:

➢ **<u>2010 оны техник туслалцааны айлчлал хийх төлөвлөгөө</u>**

6-р сард- Камбож болон Мянмар улсад

7-р сард- Филлипин, Балба, Бангладеш улсад

8-р сард- Шри Ланка, Пакистан улсад

9-р сард- БНСУ, Монгол/9-р сарын 20-ноос 23-ны өдөр/, БНАСАУ-д

11-р сард- Тайланд, Сингапур, Хонг Конг, Макао улсад

12-р сард- Малайз, Франц Полинейз улсад тус тус хийхээр

- **2010 оны сургалт, үйлдвэрлэлийн дадлага, удирдах зөвлөлийн 2-р хуралдаан**

6-р сард- ХНЖ зохиогчийн /PANS Ops FD/ анхан шатны сургалт /6-р сарын 28-наас 7-р сарын 16-ны өдрүүдэд/

7-р сард- ХНЖ зохиогчийн /PANS Ops FD/ үйлдвэрлэлийн дадлага /7-р сарын 26-наас 8-р сарын 13-ны өдрүүдэд/

9-р сард- PBN-ны ХНЖ зохиогчийн /PBN FD/ сургалт /9-р сарын 1-нээс 9-р сарын 17-ны өдрүүдэд

10-р сард- Тусгай зөвшөөрөл шаардагдах ХНЖ боловсруулах /RNP-AR/ журам зохиогчийн сургалт

11-р сард- PBN-ны ХНЖ зохиогчийн /PBN FD/ сургалт /11-р сарын 10-наас 26-ны өдрүүдэд, PBN-ны ХНЖ зохиогчийн /PBN FD/ үйлдвэрлэлийн дадлага /11-р сарын 1-нээс 19-ний өдрүүдэд, PBN-ны ХНЖ зохиогчийн /PBN FD/ үйлдвэрлэлийн дадлага /11-р сарын 29-нөөс 12-р сарын 17-ны өдрүүдэд, PBN-ны ХНЖ зохиогч багшийн сургалт/PBN FD Instructor/ 11-р сарын 25-наас 12-р сарын 17-ны өдрүүдэд

12-р сард- Удирдах зөвлөлийн 2-р хуралдаан

ИНЕГ-аас 2010, 2011 онуудад тус төвд ХНЖ боловсруулахад хамааралтай журмуудыг боловсруулах, олон улсын холбогдох бичиг баримтад нийцэж буйг шалгах, баталгаажуулах ажиллагааны сургалтуудад мэргэжлийн ажилтнуудыг хамруулахаар хүсэлт тавьж шийдвэрлүүлэв. Үүнд:

- PANS-Ops Initial – ХНЖ-ын анхан шатны сургалтанд 4 мэргэжилтэн
- PBN PANS-Ops – PBN ХНЖ зохиох сургалтанд 2 мэргэжилтэн
- Procedure Design OJT – Үйлдвэрлэлийн дадлага хийхэд 4 мэргэжилтэн
- Quality Assurance – Чанар баталгаажуулалтын сургалтанд 2 мэргэжилтэн
- RNP AR procedure design – Тусгай зөвшөөрөл шаардагдах ХНЖ боловсруулах сургалт, үйлдвэрлэлийн дадлагад тус бүр 2 мэргэжилтэн
- Regulators training – Удирдах ажилтны сургалт (боловсронгуй навигациар нислэг үйлдэх зөвшөөрөл олгох) 2 мэргэжилтэн
- ХНЖ-ыг нислэгээр шалгаж баталгаажуулах сургалтанд 2 мэргэжилтэн зэрэг болно.

ИНЕГ-ын мэргэжилтэнүүд PBN-ыг өөрийн улс оронд амжилттай хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай сургалт болон үйлдвэрлэлийн дадлагуудыг хийхэд ИКАО-ийн Ази Номхон далайн бүсийн төвөөс 3 жилийн /2010-2012/ хугацаанд зохион байгуулагдаж буй ХНЖ боловсруулах төсөлд идэвхитэй оролцогч гишүүнээр элссэн нь дараахи ашиг тусыг бидэнд олгож байгаа юм.

МСАА

/Ам. Доллар/

Д/Д	Сургалтын төрөл	Сургалтанд хамрагдах хүний тоо	Нэг хүний сургалтын зардал		Ашиг
			Идэвхитэй оролцогч гишүүн улс	Хэрэглэгч гишүүн бус улс	
1	PANS-Ops Initial – ХНЖ-ын анхан шатны сургалт	4	0	6100	24400
2	PBN PANS-Ops – PBN ХНЖ зохиох сургалт	2	0	3600	7200
3	Procedure Design OJT – Үйлдвэрлэлийн дадлага	4	0	3500	14000
4	Quality Assurance – Чанар баталгаажуулалтын сургалт	2	0	2500	5000
5	RNP AR procedure design – Тусгай зөвшөөрөл шаардагдах ХНЖ боловсоруулах сургалт	2	0	3900	7800
6	RNP AR Procedure Design OJT– Тусгай зөвшөөрөл шаардагдах ХНЖ боловсруулах үйлдвэрлэлийн дадлага	2	0	3600	7200
7	Regulators training – Удирдах ажилтны сургалт(боловсронгуй навигациар нислэг үйлдэх зөвшөөрөл олгох)	2	0	2500	5000
	ДҮН	**18**	**0**		**70600.00**

MCAA

ТАЙЛАН БИЧСЭН:
ИНЕГ-ЫН ДЭД ДАРГА Б.АЛТАНЦОМ